

“ГРАНД СИСТЕМС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

№25/01

Огноо: 2025 оны 4 сарын 28

Цаг: 09:00

Байршил: УУлаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чагдаржав гудамж 9, Ориент Плаза, 1 давхар, хурлын өрөө

Хурлын дарга: Д.Энхбилэг

Хуралд оролцсон: Тооллогын комиссын гишүүд, Хурал зохион байгуулах комисс, Хувьцаа эзэмшигчид, Хурлын дарга.

“Гранд Системс”-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 4 сарын 28-ний өдрийн 09:00 цагт нээв.

ХУРАЛ НЭЭВ

Д.Энхбилэг: Өглөөний мэнд. Өнөөдрийн хурлыг Энхбилэг би даргална. Хурлын дэгийг танилцуулав. 2025 оны 4 сарын 28-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ирцийн бүртгэлийг тооллогын комиссоос танилцуулахыг хүсэж байна.

Тооллогын комисс: Гранд Системс ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын ирцийн бүртгэлийг хийж танилцуулъя. Компанийн нийт гаргасан саналын эрхтэй 3,750,000 ширхэг хувьцаанаас 2,990,304 ширхэг хувьцаа буюу 79.74 хувийг эзэмшигч хувьцаа хуралд оролцсон буюу 79.74 хувийн ирцтэйгээр хурал хүчин төгөлдөр болохыг мэдэгдэв.

Д.Энхбилэг: Хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулав. ХЭХ-ийн материалыг хувьцаа эзэмшигчдэд БДК-аар дамжуулан илгээж, холбогдох журамд заасны дагуу танилцах нөхцөл боломжоор хангасан тул уншиж танилцсан байгаа байх.

Хэлэлцсэн нь №1:

Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах;

Д.Энхбилэг танилцуулав: Компани нь өмнө нь хамтран ажилладаг байгууллагуудын сугалааг зохион байгуулж ажилладаг байсан бол 2024 оны сүүлээр анх удаа өөрийн нэрээр нийт 11 удаа сугалаа болон урамшуулалт аян зохион байгуулж, 7 сугалааны тохирлыг явуулж, 140.5 сая төгрөгийн орлоготой ажилласан.

Компани нь 2024 оны эхээр 10 харилцагчтай байсан бол жилийн эцсээр нийт 3,278 сугалаанд оролцдог харилцагчтай болсон байна.

Санхүүгийн байдлын хувьд Компани нь жилийн эцсийн байдлаар 986.5 сая төгрөгийн нийт хөрөнгөтэй, 33.7 сая төгрөгийн өр төлбөртэй, 952.8 сая төгрөгийн эздийн өмчтэй байна. Орлогын хувьд 140.5 сая төгрөг, 306.7 сая төгрөгийн зардалтай, 166.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан. Компани нь МХБ-д бүртгүүлж, хувьцаат компани болсон, үйл ажиллагаагаа өргөжүүлж, олон нийтэд таниулах маркетинг хийсэнтэй холбоотой зардал өмнөх оноос нэмэгдсэн нь алдагдалтай ажиллахад нөлөөлсөн байна.

Хэлэлцсэн нь №2:

Хараат бус аудитын дүгнэлтийг хэлэлцэх;

Д.Энхбилэг танилцуулав: Компанийн жилийн санхүүгийн тайланд Санхүүгийн зохицуулах

хороонд бүртгэлтэй аудитийн компани болох “Цэсб-Аудит” ХХК аудит хийсэн. Аудитын компанийн зүгээс "Гранд системс" ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болгосон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлангууд, нэмэлт тодруулгыг багтаасан санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэсэн. Аудитын дүгнэлт: Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь материаллаг асуудлаар Монгол Усын "нягтлан бодох бүртгэлийн тухай хууль" болон Сангийн Сайдын тушаалаар батлагдсан заавар, журмуудад нийцүүлж үнэн зөв толилуулагдсан байна.

Хэлэлцсэн нь №3:

Компанийн бүртгэлтэй хаягийг өөрчлөх

Д.Энхбилэг танилцуулав:

Одоогийн хаяг	Өөрчлөгдөх хаяг
Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, 13, нарны зам, 62, 503 тоот	Улаанбаатар, Баянгол дүүрэг, 3-р хороо, 54 байр, 16 тоот

Хэлэлцсэн нь №4:

Компанийн дүрмийг шинэчлэн батлах;

Компанийн бүртгэлтэй хаяг өөрчлөлт орохтой холбоотойгоор дүрмийн шинэчилсэн найруулгыг батлуулахаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оруулсан болно.

САНАЛ ХУРААЛТ

Тооллогын комисс:

Санал хураалтын дүнг үндэслэн тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав.

- Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах санал хураалтын дүн:
 - Зөвшөөрсөн:** 2,990,304 ширхэг буюу **100 хувь**
 - Татгалзсан:** байхгүй
 - Түдгэлзсэн:** байхгүй тул Компанийн тухай хуулийн 63.7 дахь хэсэгт заасны дагуу шийдвэр хүчинтэй.
- Хараат бус аудитын дүгнэлтийг хэлэлцэх** тухай санал хураалтын дүн:
 - Зөвшөөрсөн:** 2,990,304 ширхэг буюу **100 хувь**
 - Татгалзсан:** байхгүй
 - Түдгэлзсэн:** байхгүй тул Компанийн тухай хуулийн 63.7 дахь хэсэгт заасны дагуу шийдвэр хүчинтэй.
- Компанийн бүртгэлтэй хаягийг өөрчлөх** тухай санал хураалтын дүн:
 - Зөвшөөрсөн:** 2,990,304 ширхэг буюу **100 хувь**
 - Татгалзсан:** байхгүй
 - Түдгэлзсэн:** байхгүй тул Компанийн тухай хуулийн 63.7 дахь хэсэгт заасны дагуу шийдвэр хүчинтэй.
- Компанийн дүрмийг шинэчлэн батлах** тухай санал хураалтын дүн:
 - Зөвшөөрсөн:** 2,990,304 ширхэг буюу **100 хувь**
 - Татгалзсан:** байхгүй
 - Түдгэлзсэн:** байхгүй тул Компанийн тухай хуулийн 63.7 дахь хэсэгт заасны дагуу шийдвэр хүчинтэй.
- Хүчингүй болсон саналын хуудасны тоо:** байхгүй


Д.Энхбэлэг: Тооллогын комиссын шийдвэрийг танилцуулсан тул 2025 оны 4 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийг танилцуулъя. Дараах шийдвэрүүдийг уншиж танилцуулав: 1. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах, 2. Жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг батлах тухай, 3 Компанийн бүртгэлтэй хаягийг өөрчлөх тухай 4. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг баталсугай.

ХУРЛЫН ХААЛТ

Үүгээр өнөөдрийн хурал өндөрлөснийг мэдэгдье. Хурлыг зохион байгуулсан ажлын хэсэг болон тооллогын комиссынхонд мөн баярлалаа. Хурал хаалаа.

Хянасан,

Хурлын дарга Д.Энхбилэг



Тэмдэглэл хөтөлсөн:

Б.Баярмаа

(тамга)

